



БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ТУСГАЙ
ХАМГААЛАЛТАЙ
ГАЗАР

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗРУУДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот
2019 оны 12-р сар

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗРУУДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Танилцуулгыг нэгтгэн бэлтгэсэн:


Г.Энхмөнх /БОАЖЯ/

Б.Мөнхчулуун /ДБХС/

Улаанбаатар хот
2019 оны 12-р сар


ГАЗАР НУТГИЙГ ТУСГАЙЛАН ХАМГААЛАХ ЗОРИЛГО

Монгол улс өөрийн орны болон бүс нутгийн байгаль экологийн тэнцлийг хангахад онцгой нөлөө бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч экологийн тэнцвэрт байдлыг хангах; газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх; ховор, нэн ховор амьтан, ургамал, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах; тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горим, дэглэмийг мөрдөн экосистемийн үйлчилгээ, үнэ цэнэ, иж бүрдлийг хамгаалж хүний амьдрах орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах; тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, түүний удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлтийг боловсронгуй болгон тогтвортой санхүүжилтийн механизм бүхий олон улсын жишигт хүрсэн хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх зорилго тавин ажиллаж байна.



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ГАЗРУУД

№	Газрын нэр	Байршил	Ангилал	Төрөл	Талбай /га/
1	Онон Балжийн А	Хэнтий аймгийн Биндэр, Дадал сум	Байгалийн цогцолборт газар	Өргөтгөл	27,867.14
2	Дэвэлийн арал-Ачит нуур	Увс аймгийн Бөхмөрөн, Ховд сум, Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум	Байгалийн цогцолборт газар	Өргөтгөл	211,552.82
3	Хомын тал	Завхан аймгийн Дөрвөлжин сум	Байгалийн цогцолборт газар	Шинээр	411,403.82
4	Гутайн даваа- Хөмүүл голын эх	Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сум	Байгалийн цогцолборт газар	Шинээр	102,690.69
5	Хангайн нуруу	Баянхонгор аймгийн Галуут сум	Байгалийн цогцолборт газар	Өргөтгөл	35,712.55
6	Баянхонгор хайрхан уул	Баянхонгор аймгийн Галуут сум	Дурсгалт газар	Шинээр	2,368.97
7	Хөх нуур-Бумбат	Баянхонгор аймгийн Гурванбулаг, Завхан аймгийн Отгон сум	Байгалийн нөөц газар	Шинээр	206,449.85
8	Хурх хүйтэний голын хөндий	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага сум	Байгалийн нөөц газар	Шинээр	193,592.58
9	Алтан хөхий уул	Ховд аймгийн Мянгад сум	Байгалийн нөөц газар	Өргөтгөл	99,611.06
Нийт					1,291,249.48
10	Орхоны Хөндий	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын төв орчим	Байгалийн цогцолборт газар	Газар чөлөөлөх	(3,108.92)



Эдгээр 9 газрыг улсын тусгай хамгаалалтад авснаар дараах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг ханган, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг биелүүлнэ.


“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”, “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”-т дэвшүүлсэн “улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт нутаг дэвсгэрийн 30 хувьд хүргэх” зорилтыг биелүүлэх:

2019 оны 9-р сарын 20-ны байдлаар нийт 31,603,476 га талбайг хамарсан 115 улсын тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулаад байна. **Төлөвлөж буй эдгээр 9 газар нь 6 аймгийн 13 сумын 1,291,249.48 га талбайг хамарч байна. Ингэснээр Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээ 32,891,617 га-д хүрч, нийт нутаг дэвсгэрийн 21 хувийг эзлэх юм.**




Ус үндэсний хөтөлбөрт “Монгол орны гадаргын усны нөөцийн 70 хувь бүрдэх сав газрын эхэд хамаарах хэсгийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ, 2016/-ийн 4.2.1-д “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авах”, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хангай, Хэнтийн нурууны усны эх, Хөвсгөл нуур орчмын газрыг Үндэсний парк байгуулах замаар улсын нөөцөд авч, уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан зорилтуудыг биелүүлэх:

Өнөөгийн байдлаар гол мөрний урсац бүрэлдэх эхийн 48.4 хувийг улсын тусгай хамгаалалтад авсан байсан бол эдгээр 9 газрыг улсын тусгай хамгаалалтад авснаар 50 хувьд хүрнэ.



Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх: Монгол улсад “Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай” Рамсарын конвенцийн жагсаалтад бүртгэгдсэн 11 газар байдгаас 6-г нь улсын тусгай хамгаалалтад хамрагдсан.

Рамсарын жагсаалтад бүртгэгдсэн Хурх Хүйтэний голын хөндий, Ачит нуур орчмын газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авснаар эдгээр газруудын хамгааллын статусыг дээшлүүлж Монгол улс Рамсарын конвенцид нэгдсэн орны хувьд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх юм.




01 ОНОН БАЛЖИЙН БЦГ-ЫН А ХЭСГИЙН ӨРГӨТГӨЛ



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Онон балж А өргөтгөл
2. Ангилал: Байгалийн цогцолборт газар / шинээр /
3. Талбайн хэмжээ: 27867,14 / га /
4. Байрлал: Хэнтий / аймаг /



ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:

✓ Гол, мөрний урсац бүрэлдэх эх, голын ай сав бүхий үнэ цэнэтэй нутаг.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас дэлхийн хэмжээнд зайлшгүй анхааран хамгаалах шаардлагатай 35 экобүсийн нэг Амар мөрний эх болох Онон голын ай савд хамаардаг. Чингэлтэй, Балж, Хөмүүл, Галттай зэрэг Онон голын томоохон цутгалуудын сав, сүлжээ төдийгүй тэдгээрийн урсац бүрэлдэх эх бүхий газар юм. Энэ утгаараа нутгийн иргэдийн аюулгүй, эрүүл амьдрах орчныг хангахад онцгой үүрэгтэй.



© Б.Ганхуяг

✓ Экосистемийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад чухал нөлөөтэй.

Ойн хувьд маш өвөрмөц бөгөөд нарс, шинэс, хус бүхий холимог ой тархдаг. Энэ нь гол мөрний ус, чийгийн горимыг тогтвортой барих зохицуулах, хуваарилах ач холбогдол өндөртэй учраас экологийн тэнцвэрт байдлыг хангахад чухал нөлөөтэй. Түүнчлэн, ойн сангийн талбайгаар тооцож үзэхэд нэг жилд 1,486,238 тонн хүчилтөрөгчийг ялгаруулж агаарыг цэвэршүүлэх экологийн үйлчилгээ үзүүлж 192,844 хүний жилийн хэрэгцээг хангадаг бөгөөд энэ нь тухайн газрыг зайлшгүй хамгаалах үнэ цэнэ, хэрэгцээ шаардлагыг харуулж байна.



© Л.Баярсайхан

✓ Ховордож буй хөхтөн амьтдын чухал орогнол, нүүдлийн коридор нутаг.

Онон, Балжийн сав газар нь экосистемийн хувьд ой, хээрийн шилжилтийн бүсэд хамаарах тул аль аль талын элементүүдийг агуулснаараа онцлогтой бөгөөд амьтан, ургамлын олон янз байдлын баялаг бүрдлээр Монгол орны бусад бүс нутгаас эрс ялгардаг. Энэ газар сибирь хандгай, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, бор туулай, монгол тарвага, дагуур зараа, нохой зээх, хүрэн баавгай зэрэг Монгол орны болон дэлхийн хэмжээнд ховордож буй хөхтөн амьтдын чухал орогнол, идээшил, нүүдлийн гол коридор нутаг болдог нь хамгааллын үнэ цэнэ, ач холбогдлыг илэрхийлнэ.



© Б.Гантулга /ДБХС/



© Б.Гантулга /ДБХС/

02 ДЭВЭЛИЙН АРАЛЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН ӨРГӨТГӨЛ


ОДООГИЙН СТАТУС:



"Рамсар"-ын конвенцийн
жагсаалтад 2004 онд бүртгэгдсэн.

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Дэвэлийн аралын байгалийн нөөц газрын хилийн заагт Ачит нуурыг хамруулан өргөтгөх
2. Ангилал: Байгалийн цогцолборт газар / шинээр /
3. Талбайн хэмжээ: 211552,82 / га /
4. Байрлал: Увс, Баян-Өлгий / аймаг /




ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:

✓ Цөлөрхөг хээрийн бүс дэх цэнгэг усны томоохон эх сурвалж.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас дэлхийн хэмжээнд зайлшгүй анхааран хамгаалах шаардлагатай 35 экобүсийн нэг болох Алтай Соёны бүсэд хамрагддаг. Талбайн хувьд томд (29,680 га) орох Ачит нуур нь Монгол Алтайн нурууны томоохон салбар Сийлхэм, Түргэний уулсын хур цас, мөсөн голоос эх авч урсах Цагаан нуур, Хатуу, Бөхмөрөн, Улиастай зэрэг голуудын усаар тэжээгдэж, илүүдэл усаа Усан хоолойн голоор Ховд голд өгнө. Ачит нуурын ус цуглуулах талбай Ховд голын ус хуралдуулах сав газрын 21%-тай тэнцүү буюу Их нууруудын хотгорын цэнгэг усны эх сурвалжийн томоохон бүрдэл хэсэг болдоороо ач холбогдолтой. Цутгал голын адаг, эсвэл эх авч урсах голын хэсэгт бага хэмжээний намагтай, эргэн тойронд нь заримдаг цөлийн ландшафт зонхилдог ба Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүх хэв шинжийг төлөөлсөн давтагдашгүй өвөрмөц ус намгархаг орчныг үүсгэдгээрээ онцлогтой.

✓ Ховордож буй амьтдын чухал орон байр, нүүдлийн коридор нутаг.

Энэ орчин нь Евразийн сэрүүн бүсийн биологийн төрөл зүйлийн томоохон төвүүдийн нэг бөгөөд амьтны хувьд янгир ямаа, цоохор ирвэс, алтайн тарвага, саарал чоно, шар үнэг, монгол тарвага, тарважи бүргэд, сар, зээрд, начин шонхор зэрэг амьтан, шувуу элбэгтэй. Зайлшгүй хамгаалах шаардлагатай амьтад бол зэгсний зэрлэг гахай, өрнийн гургуул, хар сүүлт зээр юм. Ачит нуурт алтайн сугас, монгол хадран зэрэг загас бий бөгөөд нөөцийг зохистой ашиглах механизм бүрдүүлэх ач холбогдолтой.



© Б.Гантулга /ДБХС/



© Б.Гантулга /ДБХС/




© ДБХС



© С.Цацралт



© Өнөртүвшин



✓ **Монгол Улс олон улсын өмнө үүргээ биелүүлэх томоохон алхам хийнэ.**

Ачит нуурын ёроолд хар бараан лаг шавар, нуурын захаар элс тархаж 2 м хүртэл гүехэн усанд төрөл бүрийн замаг, зэгс шигүү ургаж шувуудын хувьд таатай орчин бүрдүүлнэ. 158 зүйл шувуу бүртгэгдсэнээс 34 нь суурин, 124 нь нүүдлийн шувууд. Ийнхүү нүүдлийн шувуудын хувьд онцгой ач холбогдолтой болохыг харгалзан “Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай” Рамсарын конвенцийн жагсаалтад 2004 онд бүртгэсэн.

Ачит нуурын эргээс нэгээс хоёр км зайд татралтын хэд хэдэн дэнж байгаа нь нуурын ус их байсны ул мөр юм. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ус намгархаг газар хатаж, ширгэж, түүнд шүтэн амьдардаг биологийн төрөл, зүйлүүдийн амьдрах орчин хүчтэй өөрчлөгдөх хандлагатай байгаа учраас энэ нутгийг хамгаалан, нөөцийг зохистой ашиглан тогтвортой байдлыг хангах нь Монгол Улс өөрийн нэгдэн орсон Олон улсын конвенцийн хүрээнд үүргээ биелүүлэх томоохон алхмын нэг болно.

✓ **Аялал жуулчлалыг зохион байгуулалттайгаар хөгжүүлэн, тогтвортой хөгжлийг хангана.**

Энд ихэнхдээ дөрвөд, казак зон олон нутаглан голдуу мал аж ахуй эрхэлдэг. Мөн түүхийн дурсгал хүн чулуу, хадны сүг зураг их

бий. Ачит нуур нь ус намгархаг газар, цөлжүү хээртэй хослон оршдог үзэсгэлэнт сайхан газар тул усан аялал, наран шарлага, загасчлах аялал хөгжүүлж болохоос гадна Ямаатын ууланд янгир харах, Тэхийн усанд очиж сонирхох зэрэг байгалийн үзмэрийг түүхэн дурсгал, нутгийн иргэдийн соёлын өв уламжлалтай хослуулан аялалын цогц бүтээгдэхүүн бий болгон хөгжүүлэх бүрэн боломжтой.

✓ **Хамгааллын менежментийг хамтын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.**

Дэвэлийн аралын байгалийн нөөц газар нь Усан Хоолойн гол Ховд голд цутгах хүртэлх Ховд голын хөндий дагуу газрыг хамардаг. Ховордож байгаа амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2000 онд 10.3 мян. га талбайг хамруулан тусгай хамгаалалтад авсан. Хамгааллын менежментийн зорилгыг хэрэгжүүлэх, нөөцийг зохистой ашиглах, эрсдэл, доройтолд орж буй газруудыг анхаарч хамгаалах, нөхөн сэргээхэд хамрах талбай, хамгааллын статус нь шаардлага хангахгүй байгаа учраас зорилгыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд Ачит нуур орчмын газруудыг хамруулан, статусыг дээшлүүлэх шаардлагатай. Энэ газрыг хамгаалалтад авсан тохиолдолд зэргэлдээх хамгаалалтын захиргаадын хамтын ажиллагаа болон энд тогтвортойгоор хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэн хамгааллыг сайжруулах бүрэн боломжтой.

03 ХОМЫН ТАЛ


ОДООГИЙН СТАТУС:

Орон нутгийн хамгаалалттай газар - 25,000 га



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Хомын тал
2. Ангилал: Байгалийн цогцолборт газар / шинээр /
3. Талбайн хэмжээ: 411403,82 / га /
4. Байрлал: Завхан / аймаг /



ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:

✓ **Тахь сэргээн нутагшуулж буй 3 дахь газар.**

Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (IUCN)-ны зөвлөснөөр тахь сэргээн нутагшуулах ажлыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд байгальд бие даан амьдрах чадвартай дэд популяциудийг 5-аас доошгүй газарзүйн өөр байршилд бий болгох шаардлагатай. Хомын тал нь Монгол оронд Тахь сэргээн нутагшуулж буй 3 дахь газар бөгөөд олон улсын байгууллагуудын санхүүжилтээр 2001-2005 онд нийт 22 тахь тээвэрлэн ирснээс хойш өнөөгийн байдлаар 89 толгой болж өссөн.



© Хомын талын тахь ТББ

✓ **Олон зүйл амьтдын шүтэн амьдрах гэр орон, шилжин нүүх коридор нутаг.**

Хомын тал нь газарзүйн байршлын хувьд томоохон нуур, голууд, элсэн манханаар хүрээлэгдсэн байгалийн арал бөгөөд энд цөлөрхөг хээрийн экосистем зонхилж олон зүйл амьтдын шүтэн амьдрах гэр орон, шилжин нүүх коридор нутаг болдгоороо онцлогтой. Уг газрыг улсын тусгай хамгаалалтад авснаар дэлхийд ховордсон амьтдын жагсаалтад багтсан Монгол оронд бүртгэлтэй 69 зүйл амьтдаас 31 нь хамгаалагдах болно. Тухайлбал, дэлхийд нэн ховорт тооцогдох тахь, янгир, хар сүүлт зээр, бөхөн, зэгсний гахай зэрэг нь тогтмол байршиж, цоохор ирвэс уулархаг газраар гүйдлээр тохиолддог. Энэ нь Хомын талыг биологийн олон янз байдлын хувьд үнэ цэнэтэй нутаг болохыг харуулдаг.



© Б.Гантулга /ДБХС/

✓ **“Шувуудад чухал нутаг”**

Хомын талын өмнөд хэсэгт орших Бага нуур нь Олон Улсын Шувуудад чухал газрын жагсаалтад бүртгэгдсэн бөгөөд реликт цахлай, борцгор хотон, цагаан сүүлт усны нөмрөг бүргэд зэрэг нэн ховор, ховор шувуудын нүүдэллэх, дамжин өнгөрөх чухал газар болдог. Түүнчлэн зэрэгцээ орших Хар болон Дөргөн нуурууд нь Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц “Рамсар”-ын жагсаалтад 1999 онд бүртгэгдсэнээс харахад энэ газар нутаг шувуудын хувьд ч чухал орон байр болохыг харуулна.













© Хомын талын тахь ТББ

✓ **Байгалийн зэрлэг чацарганы өлгий.**

Завхан голын савыг дагасан Монгол оронд цөөхөн газар байдаг байгалийн зэрлэг чацарганы томоохон ойг хамгаалж, зохистой ашиглалтыг бий болгосноор орон нутгийн төсөв, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой.



ТАНИХ ТЭМДЭГ

 Сумын төв	 Сумын хил	 Улсын Тусгай Хамгаалалттай Газар	 Усан сан бүхий газрын хамгаалалтын хил	 Гол
 Аймгийн хил	 Улсын Тусгай Хамгаалалтад авахаар төлөвлөж буй газар	 Гол мөрний урсац бүрэлдэх эх	 Нуур	 Ойн сан бүхий газар

✓ Тогтвортой хөгжлийн загвар бүс нутаг болгон хөгжүүлэх бүрэн боломжтой.


Газарзүйн байршлын онцлог, тэнд байгаа ховор ба нэн ховор амьтдын баялаг байдал, ялангуяа сэргээн нутагшуулж буй тахийг түшиглэн судалгаа шинжилгээний чиглэлээр болон нутгийн иргэдэд түшиглэсэн байгальд ээлтэй аялал жуулчлал хөгжүүлэх, гадаад дотоодын хамтрагч талуудын оролцоо, хөрөнгө оруулалтыг татах, нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж улмаар байгаль хамгаалах ажлын тодорхой хэсгийг санхүүжүүлэх, тогтвортой хөгжлийн загвар бүс нутаг болгон хөгжүүлэх бүрэн боломжтой.




© Хомын талын тахь ТББ

✓ Монгол улс олон улсын холбогдох гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлнэ.

Төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээр явагдаж байсан Тахь нутагшуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг 2016 оноос “Хомын Талын Тахь” Монголын ТББ-д шилжүүлэн өгсөн ба энэ байгууллага Дөрвөлжин сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Орон нутгийн хамгаалалттай газрын менежментийг хариуцан ажиллаж байна. Сэргээн нутагшуулах ажилд гадаад орнуудын байгууллага, хувь хүмүүс дэмжлэг, санхүүжилт олгон тусалж байгаа энэ үед Монгол улс уг ажлыг онцгой анхааралдаа авч тусгайлан хамгаалснаар байгаль хамгаалах чиглэлээр Олон улсын түвшинд нэр хүндээ өсгөх, Монгол улс олон улсын холбогдох гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх юм.



© Хомын талын тахь ТББ




© Хомын талын тахь ТББ

04 ГУТАЙН ДАВАА ХӨМҮҮЛ ГОЛЫН ЭХ



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Гутайн даваа хөмүүл голын эх
2. Ангилал: Байгалийн цогцолборт газар / шинээр /
3. Талбайн хэмжээ: 102690,69 / га /
4. Байрлал: Хэнтий / аймаг /



ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:

✓ 27 голын эх, ай сав газар - цэнгэг усны үнэ цэнэтэй эх сурвалж.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас дэлхийн хэмжээнд зайлшгүй анхааран хамгаалах шаардлагатай 35 экобүсийн нэг Амар мөрний эх болох Онон голын ай савд хамаардаг. Чингэлтэй, Балж, Хөмүүл, Баруун, Зүүн Гутай, Тулгат, Шургадаг, Наймт, Арангатай зэрэг Онон голд цутгадаг 27 голын эх, сав газар. Энэ утгаараа Монгол хүний төдийгүй, Амар мөрний сав дагуух ОХУ, Хятад улсын нутагт амьдарч буй 75 сая хүний эрүүл, аюулгүй амьдрах орчныг хангахад онцгой үүрэгтэй, үнэ цэнэтэй нутаг.

✓ Ойн экосистемийн хэвийн үйл ажиллагааг хангахад чухал нөлөөтэй.

Ойн санд болц гүйцсэн болон дунд насны шинэсэн ой голлох ба хус, торлог мөн бий. Энэ нь гол мөрний ус, чийгийн горимыг тогтвортой барих зохицуулах, хуваарилах ач холбогдол өндөртэй учраас экологийн тэнцвэрт байдлыг хангахад чухал нөлөөтэй. Ойн сангийн талбайгаар тооцоход нэг жилд 5,130,864 тонн цэвэр хүчилтөрөгч ялгаруулж агаарыг цэвэршүүлэх экологийн үйлчилгээг үзүүлж байгаа нь 665,746 хүний жилийн хэрэгцээ юм. Энэ нь түүний хамгааллын үнэ цэнийг илтгэнэ.

✓ Ховордож буй хөхтөн амьтдын чухал орогнол, нүүдлийн коридор нутаг.

Энэ газар хандгай, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, хүрэн баавгай зэрэг ховордож буй хөхтөн амьтдын зүйлээр нэн баялаг болох нь судалгаагаар тогтоогдсон ба тэдний хувьд чухал орогнол, идээшил, нүүдлийн коридор нутаг болдог.

✓ Цэнгэг усны загасны нөөцийг зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлдэг.

Онон, Балж голуудад цэнгэг усны индикатор болох тул, зэвгэ, цурхай, варлан, улаан живэрт зэрэг 28 зүйлийн загас бий. 2008 оноос судалгаанд үндэслэн батлагдсан төлөвлөгөөний дагуу спорт загасчлалын аялал хөгжүүлж байгаа ба сумдын Засаг захиргаа, нутгийн иргэд, аялал жуулчлалын компани, олон улсын болон орон нутгийн байгаль хамгаалах байгууллагууд хамтран ажилладаг. Байгалийн нөөц ашигласны орлогоос тодорхой хувийг эргээд байгаль хамгаалалд зарцуулж байгаа сайн туршлага бий.

✓ Ховор ургамлын өлгий.


Энэ газар 260 зүйл ургамал бүртгэгдсэнээс 19 нь ховор, 15 нь нэн ховор ургамал. Эмийн болон ашигт ургамал нь нийт ургамлын зүйлийн 31% эзэлж байгаа нь хамгааллын үүднээс төдийгүй байгалийн нөөцийг тогтвортой ашиглах боломжийн хувьд ч нэн чухал газар болохыг баталгаажуулдаг.

✓ Хамтын оролцоо бүхий байгаль хамгаалал, нөөцийн зохистой ашиглалтын менежментийг хэрэгжүүлнэ.

Энэ газрын хилийн залгаа Онон-Балжийн байгалийн цогцолборт газар байх ба 2000 онд байгуулагдсан. Хамгаалалтын захиргаа Хэнтий аймгийн Дадал суманд байрлан үйл ажиллагаа явуулдаг. Энэ бүс нутгийн үнэ цэнийг харгалзан байгаль хамгааллын чиглэлээр олон улсын байгууллагууд төсөл хөтөлбөр тогтмол хэрэгжүүлдэг. Нутгийн иргэд бүлэг, нөхөрлөл байгуулан байгалиа хамгаалан, нөөцөө зохистой ашиглах замаар амьжиргаагаа дээшлүүлэн хамтран ажиллаж байна. Ийнхүү энэ олон талт хэрэгцээ, шаардлага, боломжийг түшиглэн хамтын оролцоотойгоор хамгаалалттай газар нутгийн менежментийг хэрэгжүүлж тогтвортой хөгжлийг хангах бүрэн боломжтой.



© Зэб Хоган, ДБХС



☑ **Уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэл өндөр байгаа тул нөлөө, эрсдлийг нэн даруй арилгах шаардлагатай.**

Энэ чухал газарт ашиглалтын 3, хайгуулын 1 лиценз бүхий талбай бий. Ашиглалтын талбайд үйл ажиллагаа эхэлсэн ба уурхайн үйл ажиллагаа үргэлжилж явагдсан тохиолдолд дараах хохирол, эрсдэл учрах болно. Үүнд:

- **Гадаргын болон гүний усны нөөц багасах, бохирдох**
Уурхай Баруун Гутай, Шургадаг голын эх, гол дээр, ойн сан бүхий газар байрладаг ба голуудыг ширгээж, устгахад хүргэж байна. Талбайгаас 2-5км-т байрлах Онон, Шургадаг, Тулгат, Баруун, Зүүн Гутай, Арангатайн голууд, 0,9-2,8км-т Хөх чулуу, Сэрүүн, Манат, Ламын, Арын булгууд болон Арангатайн рашаан, Цагаан нуур зэрэг гадаргын усыг бохирдуулах эрсдэл маш өндөр.
- **Ойн нөөц багасах, экосистемийн үйлчилгээг алдагдуулах**
Зөвхөн уурхайн ашиглалт бүхий талбайд 1,118.1 га ойн сан өртөж байгаа ба түүний экологи-эдийн засгийн үнэлгээ 22 тэр бум 420 сая төгрөг. Гэхдээ энэ хохиролд ирээдүйд энэ хэмжээний ой хэвийн ургаж байснаараа хичнээн хэмжээний хүлэмжийн хий шингээж, хүчилтөрөгч ялгаруулан экосистемийн үйлчилгээг хүртээх боломжийг бүрэн тооцоогүй.
- **Биологийн төрөл зүйл хомсдох**
Уурхайн үйл ажиллагааны дуу чимээ, тээврийн нөлөөгөөр амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөн хомсдох, гол ус бохирдсоноос загасны зүйлийн тоо цөөрч, нөөцгүй болох, тоосжилт ихэссэнээс




- хөрс доройтож, ургамлын зүйл хомсдоно.
- **15 мянга гаруй иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг зөрчин, амьжиргааны эх үүсвэрт сөргөөр нөлөөлөх**
Уурхай байрлаж буй газар Онон голын эхэд хамаардаг тул бохирдсон ус, хөрсөөр дамжин Онон голын дагуу амьдарч байгаа Хэнтий аймгийн Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал, Дорнод аймгийн Баян-Уул сумдын 15,000 гаруй Монгол хүний эрүүл орчинд амьдрах эрхийг зөрчине. Тэдний амьжиргааны гол эх үүсвэр болсон малын эрүүл мэндэд нөлөөлж, дам утгаараа малын борлуулалт буурах, эдийн засгийн хувьд сөрөг нөлөөг авч ирэх эрсдэлтэй. Энэ нь Хэнтий аймгийн түүхэн болон байгалийн аялал жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөсөн бүсэд хамаарах ба одоо хэвийн явагдаж буй спорт загасчлал, түүхэн болон байгалийн аялал, зөгийн аж ахуй эрхлэх, жимс жимсгэнэ тариалах зэрэг нутгийн иргэдийн брэнд болгон хөгжүүлж буй байгальд ээлтэй амьжиргааны бусад эх үүсвэрт, бизнест шууд сөргөөр нөлөөлнө.

05 ХАНГАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ӨРГӨТГӨЛ



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын өргөтгөл
2. Ангилал: Байгалийн цогцолборт газар / шинээр /
3. Талбайн хэмжээ: 35712,55 / га /
4. Байрлал: Баянхонгор / аймаг /



ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:



© Б.Гантулга /ДБХС/

✓ Говийн нууруудын усны горимд ихээхэн чухал үүрэгтэй - цэнгэг усны үнэ цэнэтэй эх сурвалж.

Гол, мөрний усны нөөцийн 70 гаруй хувь нь Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулсын өндөрлөг хэсэг буюу нутаг дэвсгэрийн 30 гаруй хувьд бүрэлддэг. Энэ нутаг нь Монгол орны цэнгэг усны гол нөөцийг бүрдүүлэгч Хангайн нурууны өмнөд хэсэгт байрлах ба Байдрагийн голын ай савын гол цутгалан болсон Цагаан туруут, Ёл, Их, Бага Жаргалант, Гэрт, Буянт, Хүрэм, Өлийн голуудын сав газар, гол мөрний урсац бүрэлдэх эх бүхий газар юм. Эдгээр нь гадаргын ус ховортой говийн нууруудын усны горимд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг тул энэ газар нутгийг хамгаалах нь онцгой ач холбогдолтой. Энэ нутгийг хамгаалалтад авснаар сүүлийн жилүүдэд эрчимжиж буй газрын доройтол, хөрсний эвдрэл, элэгдэл, цөлжих үйл явцыг сааруулах арга хэмжээг онцгойлон анхаарч хэрэгжүүлэх боломжтой болно.



© Б.Цэвээнравдан



© Б.Мөнхчулуун /ДБХС/

06 БАЯНХОНГОР ХАЙРХАН УУЛ

Баянхонгор аймгийн сүлд уул болох Баянхонгор хайрханыг нутгийн зон олон аав уул хэмээн хүндлэн тахидаг уламжлалтай.

Баянхонгор аймгийн Галуут суманд орших “Баянхонгор хайрхан” уулыг 2009 оны аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Аймгийн тахилгат” уул болгон 4 жилд 1 удаа тахиж байхаар шийдвэрлэсэн.



© <http://bayankhongor.khural.mn>




© <http://bayankhongor.khural.mn>



© МОНЦАМЕ

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ


1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Хайрхан уул
2. Ангилал: Дурсгалт газар / шинээр /
3. Талбайн хэмжээ: 2368,97 / га /
4. Байрлал: Баянхонгор / аймаг /



07 ХӨХ НУУР, БУМБАТ

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Хөх нуур Бумбат
 2. Ангилал: Байгалийн нөөц газар / шинээр /
 3. Талбайн хэмжээ: 206449,85 / га /
 4. Байрлал: Завхан, Баянхонгор / аймаг /
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хасалт хийсэн байдал
Тусгай зөвшөөрлийн хасагдсан талбайн хэмжээ: 17.84 га



ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:

✓ Гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах – үндэсний аюулгүй байдлыг хангах боломж.

Хангайн нуруу Төв Азийн гадагш урсгалгүй ай сав болон Хойд мөсөн далайн ай савыг зааглах усны хагалбар болдог тул Монгол орны төдийгүй дэлхийн экосистемийн тэнцвэрт байдлыг тогтвортой байлгахад онцгой үүрэгтэй. Хамгаалалтад авахаар төлөвлөж буй энэ нутаг нь Монгол орны цэнгэг усны гол нөөцийг бүрдүүлэгч Хангайн нуруунд байрлах ба Хар ус, Шар ус, Буянт, Бумбат зэрэг томоохон голуудын эх. Энэ газар нь бүхэлдээ гол мөрний урсац бүрэлдэх эх бүхий чухал газар болохын зэрэгцээ гандуу хуурайдуу уур амьсгалтай Их нууруудын хотгорын усны горимд чухал үүрэг гүйцэтгэдэг Завхан голын эх бүхий газар тул хамгааллын өндөр ач холбогдолтой. Иймээс ч Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид Хангайн нурууг бүхэлд нь хамгаалахаар заасан байдаг.

Тус нутагт олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжилсэн тархалттай тохиолдох ба ялангуяа уулын ар хажуу, уулс хоорондын хөндий хотгорт цэвдэг тогтвортой оршиж, цэвдэгт үеийн зузаан нь хэдэн арван метрээр хэмжигддэг бөгөөд энэ нь системийн тэнцвэрт байдалд ихээхэн чухал нөлөөтэй.

✓ Ховор амьтдын чухал орогнол, идээшил нутаг боловч нөөц, тоо толгой хомсдож байна.

Бумбат орчимд аргаль хонь, янгир ямаа, халиун буга, булга, суусар, чоно, тарвага зэрэг амьтад, шувуудаас алтайн хойлог зэрэг Монголд болон дэлхийд ховордож буй амьтад бий бөгөөд сүүлийн жилүүдэд тархац, тоо толгой нь цөөрсөөр байна. Иймээс тусгайлан хамгаалж нөөцийг сэргээх, өсөж үржих таатай нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Биндэръяа Хөх нуур нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нууруудын адил загасны зүйлийн бүрдлийн хувьд ядмаг боловч Олон улсын байгаль хамгаалах холбооны шалгуураар ховордож болзошгүй гэсэн ангилалд хамрагддаг алтайн давжаа сугас, говийн эрээлж, сахалт эрээлж загаснууд голлон тархдаг.

✓ Олон зүйлийн усны шувуудыг тэтгэдэг.

Хөх нуур орчим нь Хангайн нуруу дотроо шувуудын хувьд чухал газруудын нэг бөгөөд энд шилийн сар, цармын бүргэд, хотны бүгээхэй, цэвдгийн ахууна, дагуур ятуу, хар өрөвтас, өвөгт тогоруу, гангар хун, хондон ангир, хээрийн галуу зэрэг шувууд элбэг бий.



08 ХУРХ, ХҮЙТЭНИЙ ГОЛЫН ХӨНДИЙ

ОДООГИЙН СТАТУС:




конвенцийн жагсаалтад 2004 онд бүртгэгдсэн.
Орон нутгийн хамгаалалттай газар.



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Хурх хүйтний хөндий
2. Ангилал: Байгалийн нөөц газар / шинээр /
3. Талбайн хэмжээ: 193592,58 / га /
4. Байрлал: Хэнтий / аймаг /



ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:

✓ Дэлхий дээр 5 зүйлийн тогорууг нэг дор үзэх боломжтой маш цөөхөн газруудын нэг.

Энд цэн, хархираа, цагаан, өвөгт, хар, алаг тогоруу зэрэг нэн ховор, ховор б зүйлийн тогоруу бүртгэгдсэн. Цэн, хархираа, өвөгт тогоруу тогтмол өндөглөн зусдаг, алаг тогоруу нэг удаа бүртгэгдсэн бол ховорт тооцогдох цагаан, хар тогоруу зуны улиралд болон нүүдлийн үедээ үзэгддэг. Сүүлийн жилүүдэд тэдгээрийн тоо нэмэгдэж байгаа нь судалгаагаар нотлогдсон тул судлаачид болон байгаль хамгааллын мэргэжилтнүүд Монгол орны “Тогорууны нийслэл” хэмээн нэрлэдэг.



✎ Алаг тогоруу (*Grus japonensis*)

✓ Цэн тогоруу өндөр нягтшлаар үүрлэдэг газар дэлхий дээр үүнээс өөр хаана ч байхгүй.

Цэн тогоруу нь дэлхий дээр зөвхөн Зүүн Азид тархсан ба нийт тоо толгой нь 3500 орчим. Харамсалтай нь энэ тоо жилээс жилд буурч байна. Үржлийн популяцийн цөм нь Монгол орны зүүн хэсэг бөгөөд ялангуяа, Хурх, Хүйтэний голын хөндийд 70 орчим хос үүрлэн өндөглөж байгаа нь цэн тогоруу хамгийн өндөр нягтшилтайгаар үүрлэн өндөглөдөг ганц нутаг хэмээн тооцогдох гол үзүүлэлт болсон.



✎ Өвөгт тогоруу (*Anthropoides virgo*)

✓ Олон зүйлийн усны шувуудыг тэтгэдэг “чухал нутаг” гэдгээрээ дэлхийд алдартай.

Хавар, намрын улиралд буурал галуу, хошуу галуу, умардын хавтгаалж, хондон ангир, бор нугас, гангар хун, отогот шунгуур, өвөгт тогоруу хэдэн мянгаараа тогтмол дайран өнгөрдөг. Иймээс: 2004 онд Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц “Рамсар”-ын жагсаалтад бүртгэсэн; 2009 онд Шувуудад чухал хэмээн тодорхойлсон; мөн Зүүнхойд Азийн тогорууны сүлжээ нутаг, Зүүнхойд Азийн галуу ба нугасны сүлжээ нутаг, Зүүн Ази-Австралиазийн шувуудын нүүдлийн замын сүлжээ нутаг зэрэг олон улсын шинж чанартай бүхий л өргөмжлөлийг хүртсэн юм.



✎ Хар тогоруу (*Grus monacha*)

✓ Биологийн төрөл зүйлээр нэн баялаг боловч уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг газар.

Мөнх цэвдэг, өндөр уулсаас эх авсан гол, нуур, ой, татмын нуга, өвслөг хээр, уулсын атираа ихтэй зэрэг экосистемийн олон янз байдал нь зэрлэг амьтад үржиж нутаглахад тохиромжтой тул биологийн төрөл зүйлээр нэн баялаг. Усны шувуудын амьдрахад хамгийн тохиромжтой орчин нь мөнх цэвдгийн гаралтай нуурууд бөгөөд эдгээр нь уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг. Иймд энэ газар нутгийг хамгаалалтад авч хамгааллын түвшинг сайжруулах нь нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага болоод байна.




✎ Хархираа тогоруу (*Grus grus*)

✓ Ховор ургамлын өлгий.

Хэнтийн болон Монгол дагуурын хээрийн ургамлын хоёр том тойргийн зүйлүүдийг багтаахаас гадна завсарын шинжийг агуулсан тул ургамлаар маш баялаг, 230 гаруй ургамлын зүйл бий. Үүний дотор ховор ургамал ихтэй. Цэвдэгт болон хүлэрт хөрсөн дээр ургадаг хүйтэссэг ургамлын өвөрмөц бүлгэмдэл энд унаган төрхөөрөө хадгалагдан үлдсэн тул байгаль хамгааллын хувьд нэн чухал газар юм.



✎ Цагаан тогоруу (*Leucogeranus leucogeranus*)



✎ Цэн тогоруу (*Grus vipio*)

© Л.Жаргалсайхан



✓ **Монголын эртний түүх, уламжлалтай холбоотой археологийн дурсгалаар баялаг.**

Их Монгол улс байгуулагдсаныг зарласан газар Онон голын хөндийд; Хүйтэний хөндийд Чингис, Жамуха хоёрын их цэрэг тулалдаж байсан Өлзийт толгой хэмээх газар байх бөгөөд тэнд хожим гэрэлт хөшөө босгосон. Хурх голын хөндийд Рашаан хад зэрэг Чингис хаан, түүний удам угсаатай холбоотой түүхэн дурсгалт өвөрмөц газрууд олон бий.

✓ **Байгаль хамгаалал, нөөцийн зохистой ашиглалтыг хослуулсан жишиг бүс нутаг болно.**

Энд халх, буриад зон эртнээс эвтэй найртай амьдарч ирсэн бөгөөд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, соёлоо хадгалсаар ирсэн. Түүнчлэн хамгаалалтад авахаар төлөвлөж буй газрын хилийн гаднах талбай нь газар тариалангийн бүс нутаг бөгөөд энэ нь шувуудын хувьд хохирол учруулахгүйн зэрэгцээ, ус намгархаг газрыг онцгойлон анхаарч хамгаалснаар бүс нутгийн экосистемийн тэнцвэрт байдлыг ханган, улмаар орчны болон хөрсний эрүүл тогтолцоог хамгаалан үлдэх замаар газар тариалангийн хөгжлийн тогтвортой байдалд эргээд эерэгээр нөлөөлөх боломжтой. Өөрөөр хэлбэл, байгаль хамгаалал болон нийгэм-эдийн засагт харилцан ашигтай байгалийн нөөцийн тогтвортой, хамтын менежментийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой газар юм.

✓ **Олон улсын судалгаа мониторинг, байгаль хамгаалал, аялал жуулчлалын төв болно.**


Монгол улсаас Зэрлэг амьтан судлах хамгаалах төв ТББ, олон улсаас Дэлхийн байгаль хамгаалах сан, Олон улсын тогорууны сан зэрэг байгууллагууд хамтран судалгаа мониторинг тогтмол хийхийн зэрэгцээ орон нутгийн удирдлага, иргэд хамтран байгаль хамгаалах ажил хийж байна. Монголын судлаачдын хийж байгаа ус намгархаг газар, уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны суурингийн ач холбогдлыг дээшлүүлэн бүс нутгийн экологийн судалгааны суурин, түүнийг түшиглэсэн байгальд ээлтэй аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой. Жил бүрийн 6 дугаар сард “Тогорууны баяр” зохион байгуулдаг уламжлал тогтсон бөгөөд уг арга хэмжээг Хэнтий аймгийн аялал жуулчлалын бренд болгохоор аймаг, сумдууд хамтран ажилладаг. Энэ газрыг улсын тусгай хамгаалалтад авч хамгааллын статусыг дээшлүүлэн баталгаажуулсан тохиолдолд хамгааллын менежментэд Орон нутгийн захиргаад, ТББ, олон улсын байгууллагууд хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллана. Ингэснээр орон нутагт урт хугацааны хамгааллыг баталгаажуулах бүрэн боломжтой болох юм.

09 АЛТАН ХӨХИЙ УУЛЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН ӨРГӨТГӨЛ



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХААР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ГАЗАР НУТГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ


1. Улсын тусгай хамгаалалтанд авах газрын нэр: Алтан хөхий уул
 2. Ангилал: Байгалийн нөөц газар / шинээр /
 3. Талбайн хэмжээ: 99611.06 / га /
 4. Байрлал: Ховд / аймаг /
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг хасалт хийсэн байдал
Тусгай зөвшөөрлүүдийн хасагдсан талбайн хэмжээ: 14129.92 га



ХАМГААЛАЛТАД АВАХ ЧУХАЛ ҮНДЭСЛЭЛ:



© Г.Буянбат



© Б.Гантулга /ДБХС/



© Г.Нямдаваа

✓ Зэрэгцэн орших олон ялгаат экосистем нь бүс нутагтаа системийн тэнцвэрт байдлыг хангахад чухал.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас дэлхийн хэмжээнд зайлшгүй анхааран хамгаалах шаардлагатай 35 экобүсийн нэг болох Алтай Соёны бүсэд хамрагддаг. Энэ газар нь Монгол Алтайн болон Их нууруудын хотгорын мужуудын заагт орших цөлөрхөг хээрийн ландшафт бүхий нутаг бөгөөд энд Монгол орны нутаг дэвсгэрт илэрдэг өндөр уул, бэсрэг нам уулс, бэл, ухаа гүвээт тал, толгод, тэгш дэнж, хотос хөндий сайр, гүн жалга, ус намгархаг газар зэрэг олон ялгаат экосистем зэрэгцэн оршдог ороо онцлогтой бөгөөд бүс нутагтаа системийн тэнцвэрт байдлыг хангахад чухал нөлөөтэй.

✓ Цөлөрхөг хээрийн бүс дэх усан сан бүхий газар.

Энд Алтан хөхий уулаас эх аван урсах Сондуул, Баянбулаг, Бүрд зэрэг томоохон голууд бий бөгөөд цөлөрхөг хээрийн бүсэд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүх хэв шинжийг төлөөлсөн давтагдашгүй өвөрмөц ус намгархаг орчныг үүсгэдгээрээ онцлогтой.

✓ Ховордож буй ургамал, амьтдын тархац байршил, нүүдлийн коридор нутаг.

Энэ газар нь Монголд төдийгүй дэлхийд ховор цоохор ирвэс, аргаль хонь, янгир ямаа, азийн шар минж, хадны суусар зэрэг хөхтөн амьтад, алтайн хойлог, борцгор хотон, идлэг шонхор, ямаан сүүлт нугас зэрэг ховор шувууд бий боловч сүүлийн жилүүдэд тоо толгой цөөрөх хандлагатай байгаа тул зайлшгүй хамгаалах шаардлагатай.

Энд мөөг, сонгино зэрэг хүнсэнд хэрэглэдэг ургамлаас гадна хүний нүдэнд тэр бүр өртөөд байдаггүй жамъянмядаг, вансэмбэрүү, алтангагнуур, гишүү балчирган зэрэг ховор ургамал ургадаг.



© ДБХС



✓ Хамгааллын менежментийг хамтын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

Алтан Хөхий уулын байгалийн нөөц газрыг ховор амьтдыг хамгаалах зорилгоор 2010 онд 90.7 мян. га талбайг хамруулан тусгай хамгаалалтад авсан. Алтан Хөхийн уул нь далайн түвшнээс дээш дунджаар 2500-3000м-т орших ба хамгийн өндөр оргил болох Өндөр Хөхийн уул нь 3350м өндөрт өргөгдсөн. Нутгийн ардууд Алтан Хөхий уулыг 1761 оноос хойш өнөөг хүртэл жил бүр тахиж ирсэн хамгийн эртний тахилгат уулын нэг юм. 2005 оны 3 дугаар сарын 30-нд Ерөнхийлөгчийн 44 дүгээр зарлигийг гаргуулан Алтан Хөхий уулыг төрийн тахилгатай уул болгожээ.

Хамгааллын менежментийн зорилгыг хэрэгжүүлэх, нөөцийг зохистой ашиглах, эрсдэл, доройтолд орж буй газруудыг анхаарч хамгаалах, нөхөн сэргээхэд хамрах талбай нь шаардлага хангахгүй байгаа учраас зорилгыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд Хавцгай Хүрэн уул, Зээрэн нуур, Сондуул орчмын газруудыг хамруулан өргөтгөх шаардлагатай. Энэ газрыг хамгаалалтад авсан тохиолдолд хуулийн дагуу менежмент нь Ховд аймгийн өөрөө удирдах байгууллага болоод Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд зохицуулагдах ба энд тогтвортойгоор хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэн орон нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгааллыг сайжруулан ажиллах бүрэн боломжтой.



© Б.Мөнхчулуун /ДБХС/



© Б.Мөнхчулуун /ДБХС/

10 АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТӨВ ОРЧМЫН 3090.16 ГА ГАЗРЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГААС ЧӨЛӨӨЛӨХ, ХИЛИЙН ЗААГИЙГ ӨӨРЧЛӨХ

1. Улсын тусгай хамгаалалтаас хасах газрын нэр: Орхоны хөндийн байгалийн цогцолборт газраас хэсэгчилж хасах
2. Талбайн хэмжээ: 3,108.92 / га /
3. Байрлал: Өвөрхангай / аймаг /

